



КОМПАНИЙН АЖИЛЧИД ХОЛЫН ЗАЙД АЛБАН АЖЛААР ЗОРЧИХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Зорилго, хамрах хүрээ

1.1. Энэ журмын зорилго нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК /цаашид "ЭТТ" ХК гэх/-ийн ажилтан, гэрээт ажилчид, дадлагын оюутан, зочин болон жолооч хатуу хучилттай холын болон хөдөө, орон нутаг, уурхай орчмын замд тээврийн хэрэгслээр аюул осолгүй зорчих /цаашид аялал гэх/-д баримтлах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь уурхайд ажиллаж байгаа зориулалтын хүнд машин механизмаас бусад бүх тээврийн хэрэгслийг жолоодож буй жолооч болон зорчиж буй компанийн ажилтнууд, гэрээт ажилчид болон бусад зорчигчдод хамаарна.

1.3. Жолооч болон зорчиж буй компанийн ажилтан, гэрээт ажилчид дадлагын оюутан болон бусад зорчигчид аялалаар явахдаа Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм болон энэ журмыг баримтлана.

Хоёр. Аюулгүй ажиллагааг хангах

2.1. Аялалын бэлтгэлийг хангах.

2.1.1. Аялалаар явах гэж байгаа жолооч болон бүх зорчигчид энэ журамтай танилцаж сургалт, зааварчилгаа авах, хувин бэлтгэлээ хангах, цаг агаарын байдалд тохируулж хувцаслах;

2.1.2. Жолооч болон зорчигч нар зааварлагч (эрх бүхий ахлах ажилтан)-аас тусгай зааварчилгаа авсны үндсэн дээр энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан "Аялалын зааварчилгааны хуудас"-ыг бүрэн бөглөж, гарын үсэг зурна.

2.1.3. Энэ журмын 2.1.2-д заасан "Аялалын зааварчилгааны хуудас"-ыг бөглөөгүй, дутуу бөглөсөн, гарын үсэг зураагүй тохиолдолд аялалд гарахыг хориглоно.

2.1.3. Холын замд гарах гэж байгаа бол тээврийн хэрэгслийн жолооч хангалттай буюу доод тал 6-8 цаг унтаж амарсан байх шаардлгатай бөгөөд аялалыг удирдаж яваа хүн энэ талаар зохих лавлагаа, батгааг гаргуулж авна.

2.1.4. Тээврийн хэрэгслийн жолооч ажилд гарахын өмнө машинаа ажилд бэлэн эсэхийг "Тойрох үзлэгийн хуудас"-ийн дагуу өөрийн биеэр заавал шалгаж, хуудсыг бөглөсөн байна. Тээврийн хэрэгсэл эвдрэл гэмтэлтэй эсхүл багаж хэрэгсэл дутуу, гэмтэлтэй байвал засуулах арга хэмжээ авсны дараа буюу нөхөж бүрдүүлэн ажилд гарна.

2.1.5. Аюулгүй байдлаа хангах иж бүрдэл болон нэмэлт хэрэгслүүд байгаа эсэхийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан /Сансарын утас буюу IRIDIUM, майхан,

хөнжил пүүгээ, гал түлэх болон хоол хийх хэрэгсэл, газрын плитка, гар чийдэн, кенгэрү жэк г.м/ зүйлийг “Аялалд бэлтгэх хуудас”-ийн дагуу шалгана.

2.1.6.Ямар ч тохиолдолд цэвэр усны нөөцтэй явна. /Зуны улиралд машин бүрт 1-2 боодол ус, өвөл бол уснаас гадна илчлэг сайтай хоол хүнс авч явах шаардлагатай/

Гурав. Ерөнхий шаардлага

3.1.Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар зүйлд заасанчлан бүр хариуцсан техникээ бүрэн, бэлэн байлгах зорилгоор дараах үүрэгийг хүлээнэ.

3.1.1.Тээврийн хэрэгсэлийн үзлэгийг өдөр, долоо хоног тутам хийж байх;

3.1.2.Явсан км, хийсэн үйлчилгээний талаар байнга бүртгэл хөтлөх;

3.1.3.Гэмтэл, засварын талаар цаг тухайд нь механикт мэдээлж, тойрох үзлэгийн хуудсан дээр тэмдэглэж байх;

3.1.4.Зохих зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэлд засвар авахааргүй өөрчлөлт оруулахгүй байх;

3.1.5.Тээврийн хэрэгслийг байнга цэвэрхэн байлгах; зэрэг болно.

3.1.6.Хөдөө ажилд явж, ирээд энэ журмын 3 дугаар хавсралтад заасан “Техник хүлээлцэх акт”-ын дагуу тээврийн хэрэгслээ дараагийн ээлжийн жолоочид эсхүл механикт хүлээлгэж өгөх зэрэг болно.

3.2.Явах зам, маршрутын жолооч болон аялалын талаархи мэдээллийг ахлаж буй ажилтан хотхоны эсхүл уурхайн оффист мэдэгдэж байна.

3.3.Уурхайн хүний нөөцийн ажилтан тухайн тээврийн хэрэгслээр ямар зорчигч тээвэрлэхийг мэдэж байх үүргийг хүлээнэ.

3.4.Жолоочийн шууд удирдах ажилтны зөвшөөрөлгүйгээр гадны хүн тээвэрлэхийг хатуу хориглох бөгөөд онцгой шаардлагаар хэн нэгэн зорчих бол удирдах ажилтанд урьдчилан мэдээлнэ.

3.5.Тээврийн хэрэгслийн жолооч бүр дараах хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.

3.5.1.Үзлэг үйлчилгээ хийх болон нартай, цастай үед нарны шил, машины эд анги шалгах, засвар үйлчилгээ хийх үед гар түлэгдэх, зүсэгдэхээс хамгаалахын тулд бээлий өмссөн байна.

3.5.2.Уурхайн бүсэд нэвтрэх бол гэрэлтдэг хантааз, дуулга ажлын гутал өмссөн байна.

3.5.3.Хүн бүр суудлын бүсийг заавал хийсэн байна.

3.6.Зорчигч суудлын бүс хэрэглээгүйн улмаас гэмтэл авсан тохиолдолд байгууллага тухайн ажилтны өмнө ямар нэг хариуцлага, үүрэг хүлээхгүй.

3.7.Хамгаалах хэрэгслийн хүрэлцээг холбогдох хүмүүст цаг тухайд нь мэдээлж шаардлагатай бол захиална.

3.8.Хамгаалах хэрэгсэл хэрэглээгүйн улмаас үүдэн гарсан аливаа үр дагаварыг тухайн ажилтан өөрөө хариуцна.

3.9.Тээврийн хэрэглийн жолооч тохиромжгүй гутал тухайлбал хэт өндөр өсгийтэй, шаахай, улавч өмсөхгүй байвал зохино.

--- оОо ---